



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/312

Улаанбаатар хот

Төгсөлтийн дараахь гадаад сургалтын
2017-2020 оны тэргүүлэх чиглэл,
2017 оны гадаад сургалтын
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.11, 3.1.21 дэх заалт, “Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2014 оны 119 дүгээр тушаалын 2.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад оношилж, эмчлэх боломжгүй өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээнд дэвшилтэт шинэ технологи, арга зүйг нэвтрүүлэх, ховор тохиолддог өвчин, эмгэгийн оношилгоо эмчилгээг сайжруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл мэндээс шатгаалсан гадаадад гарах мөнгөн урсгал, санхүүгийн дарамтыг бууруулах зорилгоор эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтныг 2017-2020 онд улсын төсвийн санхүүжилтээр гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтад хамруулах тэргүүлэх чиглэлийг нэгдүгээр, 2017 онд улсын төсвийн зардлаар гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтад хамруулах төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны гадаад сургалтыг 2017 оны 12 дугаар сард багтаан зохион байгуулж дуусгахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д, зохион байгуулах үйл ажиллагааг удирдлагаар ханган ажиллах, тэргүүлэх чиглэлийн дагуу 2018-2020 онд улсын төсвийн зардлаар гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтад хамруулах төлөвлөгөөг боловсруулан 2018 оны 1 дүгээр улиралд батлуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/- т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хавсралтад дурдсан тэргүүлэх чиглэлд багтсан болон өөрийн байгууллагад шаардлагатай бусад чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтныг байгууллагын гадаад хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хамруулан өндөр хөгжилтэй оронд сургахад идэвхи санаачлагатай ажиллах, сургалтанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны сургалтын үр дүнг тооцож, Төрийн захиргааны удирдлагын газарт тайлагнахыг эрүүл мэндийн байгууллагын дарга/захирал нарт даалгасугай.

080394

4. Гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь танилцах аялалаас бусад сургалтыг 1 сараас багагүй хугацаагаар зохион байгуулах, сургалтад их эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, бусад шаардлагатай мэргэжилтнүүдийг багаар нь хамруулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/, эрүүл мэндийн байгууллагын дарга/захирал нарт даалгасугай.


5. Энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтад заасан сургалтын зардлыг 2017 онд батлагдсан эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараахь гадаад сургалтын зардлаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д, шаардлагатай нэмэлт зардлыг эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

6. Эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараахь гадаад сургалтын зардлыг жил бүрийн улсын төсөв, эрүүл мэндийг дэмжих сангийн төсөвт тусгахыг Бодлого төлөвлөлтийн газар /Д.Төмөртоого/, Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т, тухайн жилийн батлагдсан зардлын 20 хүртэлх хувийг үндсэн мэргэшлийн чиглэлийн сургалт болон танилцах аялалд зарцуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус даалгасугай.

7. Тушаалын хэрэгжилт болон эрүүл мэндийн ажилтны гадаад сургалтын санхүүжилт, үр дүнд дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтыг жил бүр хийж, Эрүүл мэндийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.

8. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/169 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/312 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтныг 2017-2020 онд улсын төсвийн зардлаар гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтад хамруулах тэргүүлэх чиглэл

I. Хүүхэд судлал

1. Ургийн оношилгоо, эмчилгээний арга (мэс заслын болон мэс заслын бус)
2. Дутуу нярайн өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ
3. Аутизмын оношилгоо, эмчилгээ
4. Хүүхдийн хөгжил, зан үйлийн өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ
 - хүүхдийн хэт хөдөлгөөнт ба анхаарал суларлын хам шинж
5. Хүүхдийн цусны өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ
6. Хүүхдийн дотоод шүүрлийн өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ
7. Хүүхдийн харшил, уушигны багтраа өвчний оношилгоо, эмчилгээ

II. Эх барих, эмэгтэйчүүд судлал

1. Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн өвчин эмгэгийн болон үргүйдлийн оношилгоо, эмчилгээ
 - өндгөвчний төрөлхийн дутуу хөгжлөөс үүдсэн үргүйдэл
 - төрөлхийн адреногениталь хам шинж, охидын дотоод шүүрлийн эмгэг
2. Ихэр жирэмсний үед ургаас урагт цус юүлэгдэх хам шинжийн үеийн лазер эмчилгээ
3. Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний гаж хөгжлийн үе дэх нөхөн сэргээх мэс засал

III. Гэмтэл, согог судлал

1. Гар сарвууны нөхөн сэргээх бичил мэс засал
2. Гар, сарвуу болон доод мөчний төрөлхийн хүнд хэлбэрийн дутуу хөгжил болон гэмтлийн мэс засал
3. Төрөлхийн болон шалтгаан тодорхойгүй нурууны мурийлт, хүнд хэлбэрийн нурууны гулсалтын үеийн мэс засал
4. Хүүхдийн гэмтэл, согог судлал
5. Хавсарсан хүнд гэмтлийн үеийн мэс засал
 - цээжний хүнд гэмтэл

IV. Мэс засал судлал

1. Зүрх, судасны мэс засал
 - гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн хуулралын мэс засал
 - зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал
 - зүрхний том судаснуудын гаж байрлал
 - зүрхний хавхлага солих судсан дотуурх мэс засал
 - зүрхний булчингийн хүчилтөрөгчийн хүнд хэлбэрийн дутагдлын үед механик цусны эргэлтийг дэмжих технологи (ЕСМО)

2. Мэдрэлийн мэс засал
 - паркинсон, торсион дистони, эпилепси өвчний үеийн стеротакси мэс засал
 - уртавтар тархины эмгэгийн мэс засал
 - тархины суурь хэсэг ба багана бүтцийн болон ховдлын хавдрын дурангийн мэс засал
3. Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал
 - мөч хадгалах боломжтой үеийн хавдар
4. Толгой, хүзүүний эрхтний болон цээжний хөндийн хавдрын нөхөн сэргээх мэс засал
5. Тархины суурь ясны болон нармайн хавдрын мэс засал
6. Цагаан мөгөөрсөн хоолойн хавдрын мэс засал
7. Бага аарцгийн хөндийн байрлалтай хавдрын мэс засал
8. Цээжний хөндийн байрлалтай хавдрын мэс засал
9. Хүүхдийн хавдрын мэс засал
10. Хүүхэд (нярай)-ийн зүрхний мэс засал
 - хавсарсан хүнд хэлбэрийн гажиг
11. Хүүхдийн цээж, хэвлийн дурангийн мэс засал
12. Хэвлийн мэс засал
 - цөсний замын нөхөн сэргээх мэс засал
 - гэдэсний цоргын нарийсал, залгаасыг засах нөхөн сэргээх мэс засал
13. Цээжний мэс засал
 - цээж (уушиг, улаан хоолой, голт г.м)-ний дурангийн мэс засал (VATS)
14. Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, мэс засал
 - эрэгтэйчүүдийн үрийн сувгийн эмгэгээс үүдсэн үргүйдэл
 - шээсний сүвийн арын хэсгийн гэмтлийн шалтгаант болон давсагны өмнөд ханагүй гажгийн үеийн давсагны хүзүүвч орчмыг нөхөн сэргээх мэс засал
15. Тунгалгийн судасны гаж хөгжлийн нөхөн сэргээх мэс засал

V. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгасны дараахь эмчилгээ, хяналт

1. Элэг шилжүүлэн суулгах мэс засал/донорын элгийг дурангийн мэс заслаар тайрах
2. Бөөр шилжүүлэн суулгах мэс засал
3. Зүрх шилжүүлэн суулгах мэс засал
4. Уушиг шилжүүлэн суулгах мэс засал
5. Нойр булчирхай шилжүүлэн суулгах мэс засал
6. Нүдний эвэрлэг шилжүүлэн суулгах мэс засал
7. Ясны чөмөг (аллотрансплантац) шилжүүлэн суулгах, үүдэл эсийн банк байгуулах технологи
8. Эрхтэн шилжүүлэн суулгасны дараахь дархлаа тогтолцооны хяналт, эмчилгээний үр дүнг тооцох

VI. Хавдар судлал

1. Хорт хавдрын молекул генетикийн оношилгоо, эмчилгээ
2. Хавдрын стереотактик туяа эмчилгээ
3. Хавдрын химийн "бай" эмчилгээ
4. Туяа болон хими эмчилгээний хордлогын хүндрэлийн эмчилгээ

VII. Мэдээгүйжүүлэг судлал

1. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын үеийн мэдээгүйжүүлэг (элэг, бөөр, зүрх, уушиг, нойр булчирхай, ясны чөмөг, нүдний эвэрлэг)
2. Хүүхдийн зүрхний мэс заслын үеийн зохиомол цусны эргэлт

VIII. Эрчимт эмчилгээ судлал:

1. Нярай хүүхдийн эрчимт эмчилгээ
2. Халдварт өвчний үеийн эрчимт эмчилгээ
3. Зүрх, мэдрэлийн болон эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал, хавдрын мэс засал, хавсарсан хүнд гэмтлийн мэс заслын дараахь эрчимт эмчилгээ

IX. Яаралтай тусламж/ гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

1. Нярай хүүхдийн яаралтай тусламж
 - ясанд хатгаж эм хийх технологи

X. Халдварт өвчин судлал

1. Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн оношилгоо, эмчилгээ
2. Шинээр тархаж буй халдварт өвчний оношилгоо, эмчилгээ (MERS, эбола г.м)
3. Вирусийн шалтгаант элэгний архаг өвчний эмчилгээ, хяналт

XI. Анатомян эмгэг судлал

1. Хүүхдийн эмгэг судлалын шинжилгээ
2. Эсийн эмгэг судлалын шинжилгээ
3. Иммуногистохимийн эмгэг судлалын шинжилгээ
4. Молекул патологийн шинжилгээ
5. Эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой эмгэг судлалын шинжилгээ

XII. Эмнэл зүйн эмгэг судлал

1. Эмнэл зүйн дархлаа/харшил судлал
 - аутоиммуны өвчний оношилгоо, эмчилгээ
2. Эмнэл зүйн удам зүй судлал
 - молекул генетикийн шинжилгээ
3. Эмнэл зүйн цус сэлбэлт судлал
 - донорын цуснаас сийвэнгийн бэлдмэл гарган авах технологи
 - хүйн цусны банк байгуулах технологи
 - иммуногематологийн шинжилгээ
 - цусны бүлэгнэлтийн шинжилгээ

XIII. Сэтгэц судлал

1. Настны сэтгэц судлал (өтлөлтийн үеийн сэтгэцийн өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ)
2. Хүүхэд, өсвөр үеийн сэтгэц судлал
3. Донтох өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ
4. Шүүхийн сэтгэц судлал (Полиграф аппаратын оношилгоо)
5. Эмгэг сэтгэл судлалын оношилгоо (Эгоскоп аппаратын оношилгоо)

XIV. Мэдрэл судлал

1. Тархины цусан хангамж аажмаар даамжран дутагдах өвчин эмгэгийн эмчилгээ

XV. Арьс судлал

1. Үс уналт, халцарлын үеийн оношилгоо, эмчилгээ
2. Арьс цайх өвчний үед меланоцит эс шилжүүлэн суулгах эмчилгээ
3. Хүүхдийн арьс судлал
4. Арьсны өвчин эмгэгийн үеийн шарлага эмчилгээ (PUVA)

XVI. Дотоод шүүрэл судлал

1. Чихрийн шижингийн хүндрэлийн эмчилгээ (Арьсны нөхөн төлжилтийн фактор-EGF)

XVII. Уушиг судлал

1. Уушигны эдийн шинжилгээ
2. Уушигны эмгэгийн оношилгоо, эмчилгээ

XVIII. Нүд судлал

1. Хүүхдийн ретинобластома хавдрын мэс засал
2. Торлог, шилэнцэрийн хүнд хэлбэрийн эмгэгийн мэс засал

XIX. Чих, хамар, хоолой судлал

1. Сонсголын мэдрэлийн хавдрын мэс засал
2. Вегенерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн оношилгоо, эмчилгээ
3. Меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн оношилгоо, эмчилгээ

XX. Нүүр амны мэс засал судлал

1. Уруулын сэтэрхийн мэс заслын дараа хамар хэлбэржүүлэх эмчилгээний арга
2. Хүүхдийн төвөнхийн мэс засал

XXI. Зоонозын өвчин судлал

1. Халдварт өвчний үүсгэгчийн гений дараалал тогтоох шинжилгээний арга зүй
2. Вирусын болон эгэл биетний шалтгаант зоонозын өвчний үүсгэгчийг өсгөвөрлөх шинжилгээний арга зүй

XXII. Зүрх судлал

1. Ревматологи судлал (аутоиммуны шалтгаант өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоо)

XXIII. Настан судлал

1. Настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний зохион байгуулалт

XXIV. Эмнэл зүйн хоол эмчилгээ судлал

1. Эмнэл зүйн хоол эмчилгээ

XXV. Эмнэл зүйн хордлого судлал

1. Химийн бодисын болон цацрагийн хордлогын үеийн оношилгоо, эмчилгээ, тусламж, үйлчилгээний зохион байгуулалт

XXVI. Эмнэл зүйн эм судлал

1. Эмнэл зүйн эм судлал

XXVII. Сэргээн засал судлал


1. Мэдрэлийн өвчин эмгэгийн үеийн сэргээн засах эмчилгээ
6. Хүзүү, нурууны нугас тасарсан үеийн гэмтлийн дараахь сэргээн засах эмчилгээ
2. Зүрхний өвчин эмгэгийн үеийн сэргээн засах эмчилгээ
3. Хэл ярианы гажиг засал
4. Хөдөлмөр засал

XXVIII. Спортын анагаах судлал

1. Спортын осол, гэмтлийн урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ/ сэргээн засал
2. Спортын сэтгэл судлал

XXIX. Бусад

1. Альбумин үйлдвэрлэлийн технологи
2. Агаарын бохирдлын үеийн тандалт мэдээлэл
3. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохион байгуулалт
4. Эрүүл мэндийг дэмжих, эрсдлийн үеийн мэдээлэл харилцаа
5. Эрүүл мэндийн технологийн үнэлгээний арга зүй
6. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ
7. Эмнэлгийн барилгын архитектур, зураг төсөл, барилга байгууламжыг үнэлэх арга зүй
8. Зайн анагаах ухаан



Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтныг 2017 онд улсын төсвийн зардлаар гаднаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтад хамруулах төлөвлөгөө

№	Сургалтын чиглэл	Байгууллагын нэр	Суралцах мэргэжилтэн/тоо	Хугацаа	Суралцах улс/ байгууллага
1.	Тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэн суулгах	Улсын I төв эмнэлэг	Мэс заслын их эмч-1 Мэдээгүйжүүлгийн их эмч-1 Эрчимт эмчилгээний их эмч-1 Мэс заслын сувилагч-1 Мэдээгүйжүүлгийн сувилагч-1	2 сар	БНСУ-ын Асаны анагаах ухааны төв
2.	Ясны чөмөг (аллотрансплантац) шилжүүлэн суулгах, үүдэл эсийн банк байгуулах технологи	Улсын I төв эмнэлэг	Цус судлалын их эмч-5 Бөөр судлалын их эмч-2 Элэг судлалын их эмч-1 Нүд судлалын их эмч-1 Эмнэл зүйн цус сэлбэлт судлалын их эмч -1 Эмнэл зүйн бичил амь судлал (микробиологи)-ын их эмч-1 Эмнэл зүйн эм зүйч-1 Сувилагч -4 Лабораторийн техникч-1	2 сар	БНСУ-ын Католикийн их сургууль Гэгээн мария эмнэлэг БНЭУ-ын Фортис эмнэлэг
3.	Тархины үхэлтэй донороос зурх шилжүүлэн суулгах мэс засал	Улсын I төв эмнэлэг Улсын III төв эмнэлэг	Мэс заслын их эмч-1 Мэс заслын их эмч-1	6 сар 6 сар	АНУ-ын Ютагийн их сургуулийн эмнэлэг АНУ-ын Кембрижийн их сургууль
4.	Уушигны эдийн шинжилгээ/ уушигны өвчин эмгэгийн дурангийн оношилгоо, эмчилгээ	Улсын II төв эмнэлэг	Уушиг судлалын их эмч-1 Дотрын сувилагч-1	3 сар	БНСУ-ын Сеулийн үндэсний их сургууль

№	Сургалтын чиглэл	Байгууллагын нэр	Суралцах мэргэжилтэн/тоо	Хугацаа	Суралцах улс/ байгууллага
5.	Хүзүү нурууны нугас тасарсан үеийн гэмтлийн дараахь сэргээн засах эмчилгээ	- Улсын III төв эмнэлэг - Гэмтэл согог судлалын үндэсний төв	Сэргээн заслын их эмч-2	3 сар	Япон улсын Фүжиэта их сургууль
6.	Торлог шилэнцэрийн хүнд хэлбэрийн эмгэгийн мэс заслын технологи	Улсын III төв эмнэлэг	Нүд судлалын их эмч-1	6 сар	БНЭУ-ын LV Prasad нүдний институт
7.	Нүдний эвэрлэг шилжүүлэн суулгах мэс засал	Улсын III төв эмнэлэг	Нүд судлалын их эмч-1	6 сар	БНЭУ-ын LV Prasad нүдний институт
8.	Электро физиологийн оношилгоо эмчилгээ (аблаци)	Улсын III төв эмнэлэг	Зурх судлалын эмч-4 Мэс заслын сувилагч-1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч-2	14 хоног	БНСУ-ын Анам эмнэлэг
9.	Хавсарсан хүнд гэмтлийн үеийн мэс засал/ цээжний хүнд гэмтэл	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Гэмтэл согогийн их эмч-3 Гэмтэл согогийн сувилагч -1 Эрчимт эмчилгээний эмч-1 Эрчимт эмчилгээний сувилагч-1	3 сар	БНСУ-ын Хана эмнэлэг
10.	Нуруу нугасны дурангийн мэс засал	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Гэмтэл согогийн их эмч-2 Эрчимт эмчилгээний эмч-1 Мэс заслын сувилагч-1 Эрчимт эмчилгээний сувилагч-1	3 сар	БНСУ-ын Хана эмнэлэг
11.	Меч хадгалах боломжтой үеийн яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал	- Гэмтэл согог судлалын үндэсний төв - Хавдар судлалын үндэсний төв	Мэс заслын их эмч-2	1 сар	БНСУ-ын Хавдар судлалын үндэсний төв
12.	Элэг шилжүүлэн суулгах мэс засал	Хавдар судлалын үндэсний төв	Мэс заслын их эмч-3 Мэдээгүйжүүлгийн их эмч-2 Эрчимт эмчилгээний их эмч-2 Элэг судлалын их эмч-1 Анатомын эмгэг судлалын их эмч-1 Эмнэлзүйн эмгэг судлалын их эмч-1 Эмнэл зүйн эм зүйч-1	14 хоног	БНСУ-ын Самсунг эмнэлэг

№	Сургалтын чиглэл	Байгууллагын нэр	Суралцах мэргэжилтэн/тоо	Хугацаа	Суралцах улс/ байгууллага
			Дүрс оношилгооны их эмч-1 Мэдээгүйжүүлгийн сувилагч-1 Мэс заслын сувилагч-1 Эрчимт эмчилгээний сувилагч-1		
13.	Хавдрын химийн "бай" эмчилгээ, хими эмчилгээний хордлогын хүндрэлийн эмчилгээ		Хавдрын хими эмчилгээний их эмч-1 Эмнэл зүйн эм зүйч-1	1 сар	Японы Токиогийн их сургууль
14.	Уушигны сүрьеэгийн дурангийн мэс засал	Халдварт өвчин судлалын үндэсний төв	Мэс заслын эмч-2	6 сар	БНСУ-ын Сеулийн үндэсний их сургууль
15.	Донтох өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Сэтгэц судлалын эмч-2	2 сар	ОХУ-ын Ард Түмний Найрамдлын Их Сургууль
16.	Хүүхдийн хавдрын мэс засал		Хүүхдийн мэс заслын эмч-1 Эрчимт эмчилгээний их эмч-1	4 сар 1 сар	ХБНГУ-ын Вурцбургийн их сургуулийн эмнэлэг
17.	Ихэр жирэмсний үед ургаас урагт цус юүлэгдэх хам шинжийн үеийн лазер эмчилгээ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч-1 Эрчимт эмчилгээний их эмч-1	4 сар 1 сар	Японы Осакагийн их сургуулийн эмнэлэг
18.	Өндгөвчний төрөлхийн дугуу хөгжлөөс үүдсэн үргүйдэл		Эх барих, эмэгтэйчүүдийн эмч -1 Эмбриологич-1	3 сар	БНХАУ-ын Гонгконгийн Кьюмэригийн эмнэлэг
19.	Арьс цайх өвчний үед меланоцит эс шилжүүлэн суулгах		Арьс судлалын их эмч-2	2 сар	Сингапурын Арьсны үндэсний төв
20.	Эмнэл зүйн дархлаа/харшил судлал - аутоиммуны өвчний оношилгоо, эмчилгээ	Арьсны өвчин судлалын үндэсний төв	Арьс судлалын их эмч-1	2 сар	ОХУ-ын Ард Түмний Найрамдлын Их Сургууль

№	Сургалтын чиглэл	Байгууллагын нэр	Суралцах мэргэжилтэн/тоо	Хугацаа	Суралцах улс/байгууллага
21.	Ревматологи судлал - аутоиммуны өвчний оношилгоо, эмчилгээ	- Улсын III төв эмнэлэг	Зүрх судлалын их эмч -1	3 сар	ОХУ-ын Ард Түмний Найрамдлын Их Сургууль
22.	Халдварт өвчний үсгэгчийн гений дараалал тогтоох арга зүй	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	Эмнэлзүйн эмгэг судлалын их эмч-1 Биологич-1	6 сар	БНСУ-ын Чосуны их сургууль
23.	Иммуногематологийн шинжилгээ	Цус салбэлт судлалын үндэсний төв	Эмнэл зүйн цус салбэлт судлалын их эмч-1 Лабораторийн техникч (лаборант)-1	3 сар	Японы Кинкигийн цусны төв
24.	Настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний зохион байгуулалт	Геронтологийн үндэсний төв	Настан судлалын их эмч-1 Сувилагч-1	1 сар	Японы Геронтологи, гериагрын үндэсний төв
25.	Иммуногистохимийн эмгэг судлалын шинжилгээ	Эмгэг судлалын үндэсний төв	Анатомын эмгэг судлалын их эмч-1 Лабораторийн техникч (лаборант)-1	1 сар	Японы Гүнмагийн их сургууль
26.	Эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой эмгэг судлалын шинжилгээ	Эмгэг судлалын үндэсний төв	Анатомын эмгэг судлалын их эмч-2	1 сар	БНСУ-ын Самсунг эмнэлэг
27.	Хүүхдийн мэдрэлийн өвчин эмгэг, саажилтын үеийн сэргээн засах эмчилгээ	Хүүхдийн төв сувилал	Их эмч- 1 Сувилагч-1	1сар 2 сар	Японы Олон улсын эрүүл мэнд, анагаах ухааны төв
28.	Альбумин үйлдвэрлэлийн технологи	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	Биотехнологич -2	1 сар	Бүгд Найрамдах Куба улсын үндэсний биотехнологийн институт Бүгд Найрамдах Казахстан улсын Астана хот дахь цусны төв